



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 0/335

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Худалдан  
авах ажиллагааны албаны эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 290,000 /хоёр зуун ерэн мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба /А.Айнур/-нд зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 290,000 /хоёр зуун ерэн мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнги хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба /А.Айнур/-нд үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрба даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

1150501

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын  
даргын 2020 оны 06 дугаар сарын 29 өдрийн  
01335... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: СХД-ийн Худалдан авах ажиллагааны алба

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Ус цэвэршүүлэгч HWC 350	7	ш	1	290,000.00	290,000.00	290,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				1		290,000.00	290,000.00	-			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				1.00	-	290,000.00	290,000.00	-			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө				1.00	-	290,000.00	290,000.00	-			
Актлах хөрөнгө				-	-	-	-	-			